

“ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Өмнөговь аймаг Эрүүл мэндийн газар

2018он

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1.	<p>Төсөл хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар:</p> <p>“ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР Засгийн газрын 2017 оны 225 дугаар тогтоол</p>	<p>Хөтөлбөрийн зорилго: Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино.</p>
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв
3.	Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа: 2017-2020 он	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОЭТөв, Эрүүл мэндийн газар, ӨЭМТ, СЭМТөв, СДЭ,</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: БГ,ЦГ, ХХЭМБ, Сургууль, ТБайгууллагууд</p>
4.	Хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1: Агаарын чанарыг сайжруулж , агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.</p> <p>Зорилт 2: Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангаж, хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах.</p> <p>Зорилт 3: Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны чанарыг сайжруулах.</p> <p>Зорилт 4: Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийн үед хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх.</p> <p>Зорилт 5: Эрүүл мэндийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох</p> <p>Зорилт 6: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах.</p> <p>Зорилт 7: Хүний эрүүл мэндэд химийн бодисын үзүүлэх нөлөөллийг тандан судлах.</p>

5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах, зардал)								
		Үүнд:	Төсөв (он)			Гүйцэтгэл			Хувь	
		Багц 1								
		Багц 2								
6.	Хөтөлбөрийн зорилт	Биелэлт								
	<p>1-р зорилтын хүрээнд Агаарын чанарыг сайжруулж, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.</p>	<p>1.1 “Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд”, “Агаарын бохирдлын эх үүсвэр”, “Гадаад орчны агаарын бохирдол” гэх мэт сэдвийн МСС-ны ажлын хүрээнд 1247 иргэдийг хамруулж сургалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.</p> <p>1.2 Улирлын онцлогоос шалтгаалж амьсгалын замын цочмог халдварт өвчин дэгддэгтэй холбоотой аймаг,сум, өрхийн нийт эмч, эмнэлгийн ажилчдыг томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулсан. Томуугаас урьдчилан сэргийлэх тухай сургалтад 1800 хүн хамрагдаж, 2000 зөвлөмж иргэдэд очсон байна.</p> <p>1.3 “Гэр орон байрны доторх агаарыг бохирдуулах эх үүсвэр, түүнээс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх” тухай сургалтад нийт 500 иргэн хамрагдсан. Энэ талаарх мэдээлэл, зөвлөмжийн материал 320 ширхэг тараасан байна.</p> <p>1.4 Агаарын бохирдлыг бууруулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдад 6520ширхэг 5 төрлийн мод, бут, тодорхой хэмжээний цэцгийн мандал суулгаж тарьсан байна.</p> <p>1.5 Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэхэд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй бүтээлч байдлаар илэрхийлэхийг дэмжин, хүсэл мөрөөдлийг нь тэдний нүдээр харах зорилгоор “Агаарын бохирдол бидний нүдээр” гар зургийн уралдааныг аймгийн нийт ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Уралдаанд оролцсон сурагчдын 41% нь амьд байгаль устан үгүй болж байгаа талаар, 35% нь Цахилгаан станц, үйлдвэр нэмэгдэхийн хирээр агаарын бохирдол ихсэж байгааг харуулсан, 21% нь гэр хорооллыг орон сууцжуулах саналтай байгаагаа, үлдсэн 3% нь агаарын бохирдол бидний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж, өвчлүүлж буйг илэрхийлсэн байна. Уралдаанд ирүүлсэн бүтээлээр зургийн үзэсгэлэн гаргаж тухайн үйл ажиллагааны үеэр сурагчдад агаарын бохирдлын талаар 400 ширхэг 2 төрлийн МСС-ны материал хүргэсэн.</p>								

<p>2-р зорилтын хүрээнд Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангаж, хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах.</p>	<p>2.1 Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Сэврэй сум сургуулийн сурагчдын дунд “Ус чандмань эрдэнэ” шүлгийн уралдаан зохион байгуулж сурагчдын дунд усны эрүүл ахуй, усны нөөцийн тухай мэдээлэл хийсэн.</p> <p>2.2 “Усны чанар, аюулгүй байдал”, “Ундны ус хадгалах, зөөх савны эрүүл ахуйн шаардлага”-ын талаарх сургалтыг 900 гаруй иргэнд хийж, 2756 ширхэг МСС-ны материал иргэдэд хүргэсэн байна. Мөн ус түгээх цэгүүдээс жилд 2 удаа усны дээжний шинжилгээ авч хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2.3 Нүхэн жорлон, муу усны нүх MNS 5924:2015 стандартын талаар болон эко ариун цэврийн байгууламжийн талаарх сургалтыг 636 иргэнд хийсэн ба тухайн стандартын агуулгыг багтаасан боршур 1338 иргэнд өгсөн байна. Сургалтын үр дүнд нийт 250 гаруй айл өрх сайжруулсан ариун цэврийн байгууламжийг, 120 айл өрх муу усны нүх барьж хэрэгцээндээ нэвтрүүлээд байна.</p> <p>2.4 Усны өдрийг тохиолдуулан СДЭ, СЭМТ, ӨЭМТ-үүд facebook, бусад сошиал хэрэгслээр дамжуулж мэдээлэл хүргэсэн ба Сэврэй сумын эрүүл мэндийн төв сумын FM ашиглан иргэдэд мэдээлэл хүргэсэн.</p> <p>2.5 Хөрсний бохирдлоос сэргийлж ЭМБ-ууд гадаа орчны цэвэрлэгээг сар болгон тогтмол хийж хэвшсэн.</p> <p>2.6 Баяндалай сумын цэвэр, бохирын шугамыг “Б СОПТ ХХК”-аар орон нутгийн төсвөөс 832,0 сая төгрөгийн төсвөөр их засвар хийлгэсэн.</p>
<p>3-р зорилтын хүрээнд Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны чанарыг сайжруулах</p>	<p>3.1 Орчны эрүүл мэндийн тэмдэглэлт өдрийг “Даян Дэлхийн хүнсний аюулгүй байдал, тогтвортой хангамж” уриан дор зохион байгуулж 30 сургагч багш бэлдэж, сургууль цэцэрлэгийн 400 сурагчид сургалт хийж, 800 гаруй тараах материал түгээж, 8000 гаруй иргэн цахим сүлжээгээр хандалт хийсэн. Тэмдэглэлт өдрийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 80% нь хуванцар сав болон түүний хор уршиг, тэмдэг тэмдэглэгээний талаар мэдлэг муу, 10% нь цухас ойлголттой, 10% нь буюу хуванцар сав суулганы худалдаа эрхлэгчид тэмдэг тэмдэглэгээний талаар мэдлэгтэй байсан.</p> <p>3.2 Цогтцэций сумын СДЭ нь “Шинэ хотхон” хорооллын орчны эрүүл мэндийн талаар судалгаа хийсэн бөгөөд судалгаагаар тухайн хорооллын 74% нь гэрт амьдардаг, ариун цэврийн байгууламж, муу усны нүх, ундны усны асуудлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай гэж дүгнэсэн.</p> <p>3.3 Гурвантэс сумын хувьд иргэдийн орчны эрүүл мэнд болон халдварт өвчний талаарх сургалт /орчны эрүүл мэнд, усны савны хэрэглээ, цэвэр орчин, хуванцар савны хэрэглээ, халдварт өвчин, гэх мэт/ нийтдээ 59 удаа хийсэн ба давхардсан тоогоор 1680 орчим хүнийг хамруулан , 2000 гаруй брошур тараасан.</p> <p>3.4 Номгон сумын 14-р цэцэрлэг гаднах талбайгаа тохижуулж усан оргилуур, зүлэгжүүлэлт хийсэн байна.</p> <p>3.5 Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, үерийн үеийн эрүүл мэнд, эрүүл ахуйн талаар зөвлөмж мэдээллийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад албан тоотоор хүргэсэн ба давхардсан тоогоор 8000 гаруй иргэнд энэ талаарх мэдээлэл хүрсэн байна.</p>

		<p>3.6 Аймгийн 14 сум, Даланзадгадын 8 багаас бороо, үерийн үед бохирын цооног, нүхэн жорлон хальж, хөрс бохирдсон талаар судалгаа авч судалгаан дээр үндэслэн сумдад халдваргүйтгэлийн зөвлөмж хүргүүлж, ЗӨСТ-тэй хамтран Даланзадгад сумын 371550м² талбайд халдваргүйтгэл хийсэн. Ханбогд сумын хайрхан багт ЗӨСТ-ийн ажлын хэсэг дотоод орчны 538м² талбайд халдваргүйтгэл хийсэн ба шаардлагатай гадаад орчны бүх хэсгүүдэд хөрсний халдваргүйтгэл хийсэн.</p> <p>3.7 Сэврэй сум нийт 354 өрхөд стандартын ариун цэврийн байгууламж, бохирын цооногтой айлын судалгаа хийж үзэхэд 192 өрх стандартын бохирын цооногтой, 85 өрх стандартын ариун цэврийн байгууламжтай байсан. Судалгааны үр дүнд үндэслэн айл өрх бүрийг 00 муу усны нүхтэй болох шаардлагыг хүргүүлснээр 35 өрх шинээр стандартын ариун цэврийн байгууламж, бохирын цооногтой болсон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 59 өрхөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p>
	<p>4-р зорилтын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийн үед хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх.</p>	<p>4.1 Уур амьсгалын өөрчлөлт хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө сэдвийн хүрээнд 900 гаруй иргэнд сургалт хийж, гарын авлага тараасан.</p> <p>4.2 Сэврэй сумын хувьд “гэдэсний халдварт өвчин түүнээс сэргийлэх арга зам” сэдвээр сургуулийн 89, байрны 43 хүүхдэд сургалт хийж сургалтын өмнөх мэдлэг 55,3% байсан бол сургалтын дараах мэдлэг 77% болсон үзүүлэлттэй байсан.</p>
	<p>5-р зорилтын хүрээнд Эрүүл мэндийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох</p>	<p>5.1 Эрүүл мэндийн сайдын А/505 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагуудад аюултай хог хаягдлын менежментийг зөв зохион байгуулж хэвшүүлэх тухай зөвлөмж хүргэн арга зүйгээр хангасан. Зөвлөмжийн хүрээнд дотоод сургалтаар нийт 150 гаруй эмч, эмнэлгийн ажилчид ЭМБ-ын хог хаягдлын сургалтад хамрагдсан байна.</p> <p>5.2 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн асрагч, үйлчлэгч, сувилагч нарт Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2017оны А/505 тоот тушаалын дагуу мэдээлэл өгч сургалт хийлээ. Сургалтад нийт 63 эмнэлгийн ажилтан хамрагдсан. Сургалтын өмнөх мэдлэгийг сориход 50%-тай байсан ба сургалтын дараах мэдлэг 71,3% болсон үзүүлэлттэй байна.</p> <p>5.3 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хог хаягдал түр хадгалах байрыг ашиглалтад оруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах зөвлөмж хүргэж ажилласан ба 8 дугаар сарын 10-нд зөвлөмжийн биелэлтийг хүлээж авсан.</p> <p>5.4 Аймгийн ЭМГ байгууллага дотроо ахуйн хог хаягдал ангилан ялгах хогын савыг хаягдал материал ашиглан хийж байрлуулсан. Үүнд: хаягдал цаас, хуванцар, хаягдал зай бусад хог хаягдал гэж ангилан ялгаж байна. Хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, устгах зорилгоор төрөлжүүлэн ялгахын ач</p>

		холбогдлын талаар ажилчид мэдлэг, дадалтай болсон.
	6-р зорилтын хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах.	<p>6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо зохион байгуулж ажилласан ба үүнтэй холбоотой ажлын хувцас зөв өмсөх дадал, галын аюулын үед шуурхай авах арга хэмжээ, цахилгааны аюул эрсдэлээс сэргийлэх зэрэг сургалтууд хийгдсэн байна.</p> <p>6.2 Эмнэлгийн эмч ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан.</p> <p>6.3 Зарим сумдын хувьд ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж, илэрсэн эрсдэлийг бууруулах, арилгах зорилгоор төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>
	7-р зорилтын хүрээнд Хүний эрүүл мэндэд химийн бодисын үзүүлэх нөлөөллийг тандан судлах.	<p>7.1 Анхан шатны ЭМБ-уудад “Химийн бодисын хордлогоос урьдчилан сэргийлэх” зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хүрээнд 2010 иргэдэд мэдээлэл, сургалт хийж 7 төрлийн 1470 гаруй тараах материал түгээсэн байна.</p> <p>7.2 Эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо болон иргэдэд “”Эмийн зохистой хэрэглээ”, “Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодисыг хэрэглэх зөв дадал”, “Метилийн спиртийн хордлогоос сэргийлэх”, “Ахуйн газ ба шингэрүүлсэн хийн түлшний аюулгүй ажиллагаа” гэх мэт сургалтыг зохион байгуулж, энэ талаарх мэдээллийг facebook хуудсанд байршуулж иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан ба нийт 7500 гаруй хүний хандалт авсан байна.</p> <p>7.3 Нүхэн жорлон, муу усны нүхний ариутгал халдваргүйтгэлийг ЗӨСТ намар, хаврын улиралд хийж айл өрхүүдэд зөвлөгөө өгсөн.</p>
7	Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/	<p>Ололттой тал- Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох олон төрлийн МСС-ны үйл ажиллагаа зохион байгуулагдсан ба мэдээллийн хэрэгсэл, тараах материалаар дамжуулан мэдлэг олгох үйл ажиллагаа түлхий хийгдсэн.</p> <p>Дутагдалтай тал- ЭМБ-ууд аюултай хог хаягдлын асуудалд А/505 тоот тушаалын дагуу анхаарч ажиллаж байгаа хэдий ч энгийн хог хаягдлыг ангилан ялгадаггүй, дахин боловсруулалтын талаар мэдлэг, туршлага, дадал бага байна.</p> <p>Анхаарах асуудлууд- Анхан шатны ЭМБ-ууд өөрийн харъяаны хүн ам, айл өрхийн дунд орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн зорилт дахь олон асуудлаар судалгаа хийж, судалгаанд үндэслэсэн үйл ажиллагаа зохион байгуулах шаардлагатай байна.</p>

8.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт										
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6	Зорилт 7	
		71,4%	7	75	60	80	60	80	65	80	
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ									

Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн: У.Үүрийнтуяа